



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭДЭЭ

№151 /365/

2022.08.25

Цаг үе, үйл явдал

МОНГОЛ ЦЭРГИЙН МУЗЕЙД “БАЙР ЗҮЙЧДИЙН БУЛАН”-Г БАЙГУУЛАХ НЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛЛОО

Зэвсэгт хүчний 284 дүгээр анги үүсгэн байгуулагдсаны 40 жил, Байр зүйн албаны 90 жилийн ойд зориулан өнөөдөр буюу 8 дугаар сарын 25-ний өдөр Монгол цэргийн музейд “Байр зүйчдийн булан”-г байгуулах нээлтийн үйл ажиллагаа боллоо.

Нээлтийн үйл ажиллагаанд ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын орлогч дарга хурандаа Ц.Батсайхан, Монгол цэргийн музейн захирал хурандаа Д.Ганзориг, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын геодези, зураг зүйн хэлтсийн дарга Д.Мөнхцэцэг, Зэвсэгт хүчний 284 дүгээр ангийн удирдлага, ахмадын төлөөлөл оролцлоо.

Зэвсэгт хүчний 284 дүгээр ангийн захирагч Хурандаа Б.Даваа-Очир:

“Зэвсэгт хүчний 284 дүгээр ангийн хамт олон түүхэн тэмдэглэлт 90 жилийн ойдоо зориулж “Байр зүйчдийн булан”-г Монгол цэргийн музейд байгууллаа. Монгол улс дархан хилээ тогтоож, хилийн тэмдэгтэй байрлуулан, НҮБ-д нэрээ бүртгүүлж тусгаар улс болоход байр зүйчдийн маань үзүүлсэн гавьяа зүтгэл их билээ. Бидний түүхэн замнал, нэр алдрыг мөнхлөхөд мэргэжлийн туслалцаа үзүүлсэн Монгол цэргийн музей болон энэхүү үзүүлэнг хийж олны хүртээл болгоход гар бие оролцсон ангийн хамт олондоо талархснаа илэрхийлье. Музей гэдэг өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагийн хэлхээс болсон зүйл. Цаашдын үе, үеийн байр зүйчид маань үүгээр зочилж, үйл ажиллагааг нь сурталчилж, илүү өргөжин дэлгэрэхэд туслалцаа үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.”

Зэвсэгт хүчний 284 дүгээр ангийн захирагч асан бэлтгэл Хурандаа Н.Баярсайхан



“Зэвсэгт хүчний 284 дүгээр анги нь Батлан хамгаалах салбар, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлал, бусад байгууллагуудыг улсын хил, газар нутгийн хэмжээг тодотгон тогтоох, газрийн гадаргуугийн бодит байдал түүн дээр орших бүх объектийг геодезийн өндөр нарийвчлал бүхий дүрсэлсэн цэргийн байр зүйн зураг, өгөгдлүүдээр хангаж ажилладаг ажилсаг хамт олон. Энэхүү булан байгуулах үйл хэргийг миний ажиллаж байх үед бодож, төлөвлөж байсан хэдий ч өдгөө ийм сайхан зүйлийг хийж гүйцэтгэх чинээ хэмээн санасангүй. Б.Даваа-Очир даргатай хамт олон

үүнийг хийж бүтээж чаджээ гэдгийг нүдээр харах сайхан байна.”
Монгол цэргийн музейн захирал хурандаа Д.Ганзориг:
“Монгол цэргийн музейд нэгэн шинэ булан мэндэлж, үзвэрийн сан хөмрөгөө тэлсэн баярт сайхан үйл явдал боллоо. Байр зүйн алба ямар чухал ач холбогдолтой гэдгийг таниулах булантай, үзүүлэх үзэмтэй болсонд ЗХЖШ болон Ажиллагааны удирдлагын газрын хамт олон баяртай байна.”
Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын геодези, зураг зүйн хэлтсийн дарга Д.Мөнхцэцэг
Монгол улсын нутаг дэвсгэрийн

бүрэн байдал, тусгаар тогтнол, батлан хамгаалах салбар, байгаль орчин, уул уурхай, зам тээвэр гэх мэтчлэн бүх салбарт геодези, зураг зүйн шинжлэх ухаан хүрч ажилладаг. Байр зүйн зураг, геодезийн сүлжээ байгуулах зураг зүйн материалаар хангаж улс орныхоо бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнолд үнэтэй хувь нэмэр оруулан ажилладаг Зэвсэгт хүчний 284 дүгээр ангийн хамт олондоо монгол цэргийн музейд өөрийн үйл ажиллагааг сурталчлах, танин мэдэхүйн булантай болсонд баяр хүргэе” гэсэн юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

Өдөр	Шөнө
☀️ 12	🌙 0


ӨМНӨД СУДАН

Өдөр	Шөнө
☀️ 31	🌙 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.213	3.220
EUR 🇪🇺	3.227	3.240
CNY 🇨🇳	471	473
RUB 🇷🇺	50	50.30
JPY 🇯🇵	23.55	23.68
KRW 🇰🇷	2.39	2.41

ЗУРХАЙ



2022.08.25 /ПҮРЭВ ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 27

ЗУНЫ АДАГ УЛААГЧИН ХОНЬ САРЫН ЕСӨН УЛААН ЦАГААН НОХОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Хэрүүл тэмцэл ирнэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 06.01-19.48

Барилдлага:

Хучин төгсөх

Шүтэн барилдлага:

Төрөн түгэхүй

Суудал: Төмөр

Энэ өдөр бар, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, байшингийн суурь тавих сайн. Эрдэнийг гадагш өгөх, нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийхэд муу.

Хол газраар яваар одогсод баруун урагш зүгт мөрөө гаргавал зохистой.

АХЛАГЧ Г.БАТ-ИРЭЭДҮЙ ОРГИЛ ТУЛААНАА ХИЙНЭ



Зэвсэгт хүчний 014 дүгээр анги

Гардан тулааны сургагч багш Ганбаатар овогтой Бат-Ирээдүй маргааш буюу 8 сарын 26-нд “Undeatead” холбооны Main event буюу оргил тулааныг хийнэ. Г.Бат-Ирээдүйн “MGL1” Монголын шилдэг тулаанчдын холбооны шилдэг 10-т жагсдаг. Хэрэв тустулаанд ялалт байгуулбал эхний 5-т орох боломжтой юм. Энэхүү хариуцлагатай чухал тулаанд ахлагч Г.Бат-Ирээдүйг дэмжихийг хүсвэл маргааш 112 академид хүрэлцэн ирж тэмцээнийг үзэх боломжтой юм. Дэслэгч Р.Билэг

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 603,672,763

Эдгэрсэн

Нийт: 578,518,860

Нас барсан

Нийт: 6,480,860

“ДӨЛ-2022” ЦЭРЭГ-СПОРТЫН ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭН ЭХЭЛЛЭЭ



Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдаж байгаа Батлан хамгаалахын сайдын нэрэмжит улсын аварга шалгаруулах “Дөл-2022” цэрэг-спортын цогцолбор тэмцээн Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд эхэллээ. Цогцолбор тэмцээнд 21 аймаг, 9 дүүргийн шилдгээр шалгарсан тасгуудын 400 орчим сурагч оролцож байна.

Цогцолбор тэмцээний нээлтийн ёслолд Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Ч.Гандирваа, Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын ерөнхий газрын Суралцагчийн хөгжлийн газрын дарга Ж.Болормаа, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Д.Жаргалсайхан нарын холбогдох албаныхан, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын удирдлага, тамирчин сурагчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд оролцлоо.

Тэмцээний нээлтийн ёслол Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн Хүндэт харуул Батлан хамгаалахын сайдыг ёслол төгөлдөр угтан авснаар эхэлсэн бөгөөд үргэлжлүүлэн тэмцээний Ерөнхий шүүгч, ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын Биеийн тамир, спортын тасгийн дарга, хурандаа Д.Цог-Эрдэнэ тамирчинсурагчдыг бэлэн жагссан тухай илтгэлээ.

Батлан хамгаалахын сайд



Г.Сайханбаяр тэмцээнийг нээж хэлсэн үгэндээ

“Улс орны дөрвөн зүг, найман зовхисоос хүрэлцэн ирж, хурд хүч, авьяас чадвараа дайчлан оролцож байгаа сурагчид, багш-дасгалжуулагч Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. “Дөл” тэмцээн нь хүүхэд, залуучуудыг зөв ёс суртахуунтай, хувийн зохион байгуулалттай, зорилго тэмүүлэлтэй иргэн болон төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой төдийгүй анги, хамт олны эв нэгдэл, сургалтын чанар, хувь хүний хүмүүжилд эергээр нөлөөлдгийг

дурдахад таатай байна. 2015 онд батлагдсан “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичиг болон Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-т “Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт хүүхэд, залуучуудад цэрэг-эх оронч үзэл, хүмүүжил олгох хичээлийн хөтөлбөрийг тусгаж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлнэ” гэж заасан. Энэхүү төр, засгаас баталсан бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд цэрэг-

спортын “Дөл” цогцолбор тэмцээн нь өндөр ач холбогдолтой юм. Тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байгаа Ерөнхийлөгчийн Тамгын газар, Боловсрол, шинжлэх ухааны яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, түүний Тамгын газар, Цэргийн штабууд, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Биеийн тамир, спортын улсын хороо, Ерөнхий боловсролын сургуулиуд болон Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн удирдлага,

хамт олонд талархал илэрхийлье” гээд эр зориг, тэсвэр хатуужлаа сорин өрсөлдөх 29 багийн 400 гаруй тамирчин сурагчдад өндөр амжилт хүслээ. Үүний дараа Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын ерөнхий газрын Суралцагчийн хөгжлийн газрын дарга Ж.Болормаа “Дөл-2022” цэрэг-спортын цогцолбор тэмцээнийг анх удаа Ерөнхийлөгчийн ивээл дор өргөн хүрэн зохион байгуулж байгаа Батлан хамгаалах яамныхандаа баярлалаа. Улсорны маань ирээдүй болсон өсвөр үе, хүүхэд залуучуудыг цэрэг-спортоор дамжуулан эх оронч үзэл төлөвшилтэй

иргэн болгон бэлтгэхэд цогцолбор тэмцээний гол ач холбогдол оршиж байна” гээд тэмцээний үйл ажиллагаанд амжилт хүссэн юм. Нээлтийн ёслолын төгсгөлд ҮБХИС-ийн харьяа “Тэмүүжин-Өрлөг” дунд сургуулийн сурагчид жагсаалын үзүүлэх тоглолт, Зэвсэгт хүчний 150 дугаар ангийнхан гардан тулааны үзүүлэх тоглолтыг тус тус толилуулж, тэмцээнд оролцогч баг тамирчид цэргийн ёслолын жагсаалаар алхсан юм.

Ахлах дэслэгч Д.БОЛОР